



# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2021 он

БИД БЭЛЭН ҮҮ ?

# БИД БЭЛЭН ҮҮ?

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн ихэнх салбарууд зогсонги байдалд шилжсэнтэй холбоотой өсөлт 1.4 хувьтай гарлаа. Хүн амын вакцинжуулалт, тээвэр ложистикийн сэргэлтийн хурдаас хамааран эдийн засаг сэргэх хандлагатай байна. Үүнээс гадна Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн хурдад төрөөс авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ, тохируулга чухал нөлөөтэй.

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив 2.3 хувиар нэмэгдэж ДНБ-ийн хэмжээнд ойртлоо. Геополитик, гадаад худалдаанаас шалтгаалж санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал, эрсдэл байсаар байна. Сүүлийн 2 жил гаруйн хугацаанд мөнгөний болон сангийн тэлэх бодлогын хүрээнд ААН-үүдэд хөнгөлөлттэй зээлүүд олгож эхэлсэн. Зээлийн хуваарьт өөрчлөлт оруулсан иргэд, ААН-үүд, ажлын байрыг дэмжих зээл авсан ААН-үүд 2022 онд зээлээ төлж эхлэх бөгөөд ингэснээр чанаргүй зээл нэмэгдэх магадлалтай.

Банкны тухай хуулийн хүрээнд, системийн нөлөө бүхий 5 банк IPO гаргахаар бэлтгэл ажлаа хангаж буй хэдий ч таамаглаагүй гадаад хүчин зүйлээс үүдэлтэй олон улсын санхүүгийн цочролтой үед иргэд, хөрөнгө оруулагчид энэ үйл явцад бэлэн байна уу?




## 2021 онд зөвхөн уул уурхай болон ХАА-н салбарын зээл олголт нэмэгдсэн байна.

Уул уурхай, ХАА-с бусад салбаруудын зээл олголт бууралттай байна.  
Иргэдийн зээлийн хувьд, автомашины зээл хамгийн огцом буурчээ.



Онцлох өөрчлөлт,  
энгийн тайлбар

Онолын  
тодорхойлолт



2021 оны 2-р  
улирлын  
гүйцэтгэл

Банкны шинээр олгосон  
зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан  
зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл  
нэмэгддэг.

-6%

Шинээр олгосон зээлийн  
хэмжээ жилийн 6 хувиар  
буурчээ.

## 2021 ОНЫ БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА

---



Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд 3 хувийн хүүтэй зээл болон репо санхүүжилтийн нөлөөгөөр нийт зээл 21 хувиар өсөв.



Зээлийн хүү бууруулах стратегийн хүрээнд зээлийн сарын хүү 1.19 хувь болж зорилтот түвшинд хүрлээ.



Тээвэр ложистикийн хэвийн биш үйл ажиллагаанаас үүдэлтэй хэрэглээ хязгаарлагдаж, хадгаламж нэмэгджээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна. Зээл өсөлттэй, зээлийн чанар нь сайжирсан, эх үүсвэр болон өөрийн хөрөнгө өсөлттэй байна.



2022 оны дундаас хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүдийн зээлийн эргэн төлөлт эхэлнэ. Энэ нь бизнесийн зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.



Ирэх 4 сарын хугацаанд системийн нөлөө бүхий банкууд IPO хийхээр байгаа зэрэг нь энэ үед томоохон сорилт байхаар байна.

# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

---

2021 он

---

## Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


# +21%

Зээлийн үлдэгдэл дунджаар 21 хувиар өсөв.

Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Ажлын байрыг дэмжих зээл банкуудын зээлийн өсөлтөд чухал нөлөө үзүүлэв.


Ипотекийн зээл болон “10 их наяд төгрөгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд олгогдож буй репо санхүүжилт, 3 хувийн хөнгөлөлттэй зээлүүд нь банкны зээлийн тасралтгүй өсөлтийг бий болгов



## 2021 онд иргэдэд олгосон зээл тогтмол нэмэгдэв.

Иргэдэд олгож буй цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл нэмэгдэв.  
Эдийн засгийн идэвхжил сул байсан тул банкууд эрсдэл багатай зээл олгох сонирхолтой байв.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн эцэст



## Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.


Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ өсөв.

# 38%

## 2021 онд эдийн засгийн голлох салбаруудын зээл олголт нэмэгджээ.

Ажлын байрыг дэмжих 3 хувийн зээлийг банкууд өөрийн санхүүжилтээр олгож буй нь эдийн засгийг дэмжих хөшүүрэг болж байна. Хөл хорионы нөхцөл байдлыг аажмаар сулруулсан нь худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа сэргэхэд нөлөөлжээ.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн эцэст



## Банкны шинээр олгосон ЗЭЭЛ

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Бизнесийн зээлийн  
ХЭМЖЭЭ ӨСӨВ.


49%




## Хэрэглээний зээлийн багцын чанар аажмаар муудаж байна.

Төрөөс өрхөд өгч буй тэтгэмж, тусламж аажмаар буурч хэвийн түвшинд хүрнэ. Иймээс өрхийн орлого нэмэгдэхгүй бол зээлийн чанар муудах эрсдэлтэй. Ажлын байрыг дэмжих зээлийн эргэн төлөлтүүд 2022 оноос хийгдэж эхлэхэд ААН-үүдийн зээлийн төлбөрийн дарамт нэмэгдэхээр байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



## Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд  
чанаргүй зээлийн харьцаа

# 8.5%

Монгол Улс нь бизнес эрхлэхэд таатай улсуудын жагсаалтад 190 улсаас




Эх сурвалж: Дэлхийн банк, Doing Business 2020


## Зээлтэй холбоотой маргаан үүсэхэд авлага барагдуулахад хүндрэлтэй байна.

Манай улсын хувьд бизнес эрхлэхэд таатай орнуудын жагсаалтад 81 дүгээр байр эзлэхэд дэд бүтцийн асуудал болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал сөргөөр нөлөөлсөн бол зээл авахад хялбар байдал нь эергээр нөлөөлжээ.

Зээл авахад хялбар байдлаараа манай улс бүс нутагтаа тэргүүлж байна.



Зээлтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд авлага барагдуулахад хүндрэлтэй байна.




Манай улсад зээл,  
авлагатай холбоотой  
маргаан шийдвэрлэх  
хугацаа дунджаар

4 жил

Эх сурвалж: М.Энхтөр, Л.Даваажаргал, Б.Гэрэлмаа, Б.Энхсүрэн,  
Л.Гантогтох, Б.Мөнхжаргал – Чанаргүй зээл барагдуулалтын судалгаа 2020

## Бизнесийн зээл барагдуулахад 925 хоног зарцуулдаг байна.

Маргаан шийдвэрлэх хугацаанд нийт зээл, авлагын 15 хувийг шүүхийн зардалд зарцуулдаг. Ийнхүү зээл, авлагын ердөө 18.2 хувийг эргүүлж олж авч чаддаг байна.




## Хэрэглээний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын боломж дутмаг байдал нь хадгаламжийг нэмэгдүүлжээ.

Цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй олон хоногийн хөл хорио, тээвэр ложистикийн хэвийн биш үйл ажиллагаанаас үүдэлтэй хэрэглээний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын боломж дутмаг, валютын ханшийн харьцангуй тогтвортой байдал нь төгрөгийн хадгаламж нэмэгдэх хөшүүрэг болжээ.

Харилцах, хадгаламжийн дүн

Их наяд ₮



## Банкны эх үүсвэр


Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж өсөв.

+13%

# Зээлийн хүү бууруулах стратегийн хүрээнд зээлийн хүү түүхэн доод түвшинд хүрлээ.

2021 оны хагас жилд ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлийг тооцож, оруулсан зээлийн хүү 11.5 хувь хүрээд байсан бол жилийн эцэст 1.5 нэгж хувиар нэмэгдэж 13.5 хувьд хүрчээ.



## Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү

# 14.3%

# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

---

2021 он

---

## Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий  
банкуудын актив өсөв.

# 12%


Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Банкны системийн нийт актив 4.3 их наяд төгрөгөөр өссөн бөгөөд үүний дийлэнх хувийг системийн нөлөө бүхий банкуудын активын өсөлт бүрдүүлж байна.

Хаан банк болон ХХБанкны актив 1.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

### Банкуудын нийт актив

Их наяд ₮




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# Хөнгөлөлттэй зээлийн нөлөөгөөр банкуудын зээлийн багц 3.4 их наяд төгрөгөөр өсөв.

2021 онд банкуудын зээлийн багц өссөн хэдий ч системийн нөлөө бүхий банкуудын 10 зээл тутмын нэг нь чанаргүй байна. Хаан банкны зээлийн чанаргүйдэл өссөн байгаа бол Хас банк хамгийн бага буюу 5 хувийн зээлийн чанаргүйдэлтэй байна.

Банкуудын зээлийн үлдэгдэл

Их наяд ₮



## Банкны нийт зээлийн үлдэгдэл

Жич: Иргэд, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ.

Системийн нөлөө бүхий банкуудын зээлийн багц өсөв.

# 23%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайла



## Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр нэмэгдэв.

# 9%


Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## 2021 онд банкны салбарын нийт эх үүсвэр 4.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 0.9 их наяд төгрөгөөр өссөн байна.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн нөлөөгөөр банкуудын харилцах өмнөх жилээс 46 хувиар өсжээ.

### Банкуудын эх үүсвэр



Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

## Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

# 15%


Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж байна.

Эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд банкууд ЖДҮ-дэд зээл олгож буй нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бууруулахад нөлөөлөв.

Хаан банк эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн зээлийг хамгийн ихээр гаргаж буй нь тус банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурахад нөлөөлжээ.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ




2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Эх сурвалж: Банкуудын тайлан

# Системийн нөлөө бүхий 5 банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Цар тахал гарсантай холбоотой хөтөлбөрийн зээлээс бусад зээлийн олголт өсөөгүй байна. Улмаар банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Хөрвөх чадварын харьцаа



2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

## Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

# 41%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлаг

Эх сурвалж: Монголбанк Үндэсний Статистикийн Хороо

# БАНКУУД ГРО ХИЙХЭД БЭЛЭН ҮҮ?

---

2021 он

---

# БОГД БАНК

<b>2014 он</b> Үүсгэн байгуулагдсан	<b>500 мянга</b> Харилцагч
<b>1%</b> Зах зээлд эзлэх хувь	<b>327 тэрбум ₮</b> Нийт хөрөнгө
<b>8</b> ATM	<b>11</b> Салбар
<b>95.7 тэрбум ₮</b> Хадгаламж	<b>10.3 тэрбум ₮</b> Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас

## Олон нийтэд хувьцаагаа амжилттай арилжааллаа

Богд банк нь нийт хувьцааныхаа 20 хувийг буюу 12.5 сая ширхэг хувьцааг нэг бүр нь 2,540 төгрөгөөр олон нийтэд санал болгох замаар 31.75 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

### Хувьцаа эзэмшигчид



### Нийт хөрөнгийн өсөлт | тэрбум ₮



### Өөрийн хөрөнгийн өгөөж | тэрбум ₮



### Зээлийн чанаргүйтэл



# ХААН БАНК


<b>1991</b> Үүсгэн байгуулагдсан	<b>2.6 сая</b> Харилцагч
<b>33.2%</b> Зах зээлд эзлэх хувь	<b>13.6 их наяд ₮</b> Нийт хөрөнгө
<b>1,275</b> ATM	<b>547</b> Салбар
<b>7.0 их наяд ₮</b> Хадгаламж	<b>292 тэрбум ₮</b> Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас

## Хаан банк нь манай улсын хамгийн олон харилцагчтай банк

Монгол Улсын хэмжээнд нийт айл өрхийн 70 гаруй хувь болон 50,000 орчим байгууллагад банк, санхүүгийн үйлчилгээг улс орон даяар хүргэдэг.

### Хувьцаа эзэмшигчид



- HS Holdings CO., Ltd
- Таван Богд Трейд ХХК
- Д.Хулан
- Эйч Эс Интернэйшнл
- Хаан банк ажилтнууд

### Өөрийн хөрөнгийн өгөөж | их наяд ₮



### Нийт хөрөнгийн өсөлт | их наяд ₮



# ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК

**1990**  
Үүсгэн  
байгуулагдсан

**500 мянга**  
Харилцагч

**23.4%**  
Зах зээлд эзлэх  
хувь

**9.6 их наяд ₮**  
Нийт хөрөнгө

**283**  
ATM

**91**  
Салбар

**3.9 их наяд ₮**  
Хадгаламж


**90 тэрбум ₮**  
Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас

## Худалдаа, хөгжлийн банк нь Монгол Улсын ууган арилжааны банк

Гадаадын томоохон банк санхүүгийн байгууллагуудтай хамтран бизнесийн зээлийг олгодог ба Монгол Улсын гадаад төлбөр тооцооны 78 хувийг дангаараа гүйцэтгэдэг.

### Хувьцаа эзэмшигчид



### Өөрийн хөрөнгийн өгөөж | их наяд ₮



### Нийт хөрөнгийн өсөлт | их наяд ₮



# ГОЛОМТ БАНК


<b>1995</b> Үүсгэн байгуулагдсан	<b>800 мянга</b> Харилцагч
<b>19.3%</b> Зах зээлд эзлэх хувь	<b>7.9 их наяд ₮</b> Нийт хөрөнгө
<b>176</b> ATM	<b>101</b> Салбар
<b>3.6 их наяд ₮</b> Хадгаламж	<b>22 тэрбум ₮</b> Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас

## Манай улсад цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй банк

Дотоодын кредит картны 36 хувь, алтны арилжааны 54 хувь, гадаад баталгааны 73 хувийг тус тус гүйцэтгэдэг.

### Хувьцаа эзэмшигчид




- Голомт  
файнэншил  
Групп ХХК
- Свисс-Мо  
Инвестмэнт Эй  
Жи
- Голомт  
инвестмэнт  
Лимитэд

### Өөрийн хөрөнгийн өгөөж | их наяд ₮



### Нийт хөрөнгийн өсөлт | их наяд ₮





# ТӨРИЙН БАНК


<b>2009</b> Үүсгэн байгуулагдсан	<b>1.9 сая</b> Харилцагч
<b>9.3%</b> Зах зээлд эзлэх хувь	<b>3.8 их наяд ₮</b> Нийт хөрөнгө
<b>347</b> ATM	<b>495</b> Салбар
<b>2.2 их наяд ₮</b> Хадгаламж	<b>52 тэрбум ₮</b> Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас


## Төрөөс олгож буй үйлчилгээнүүдийг иргэдэд хүргэж буй банк

Монгол Улсын хэмжээнд тэтгэвэр болон 100 гаруй төрлийн нийгмийн халамжийн мөнгө олгох ажлын 80 гаруй хувийг дангаар гүйцэтгэдэг.


### Хувьцаа эзэмшигчид



### Өөрийн хөрөнгийн өгөөж | тэрбум ₮



### Нийт хөрөнгийн өсөлт | их наяд ₮



# ХАС БАНК

**2001**  
Үүсгэн  
байгуулагдсан

**1 сая**  
Харилцагч

**8.5%**  
Зах зээлд эзлэх  
хувь

**3.5 их наяд ₮**  
Нийт хөрөнгө

**360**  
АТМ

**78**  
Салбар


**1.8 их наяд ₮**  
Хадгаламж

**62 тэрбум ₮**  
Цэвэр ашиг

Эх сурвалж: Банкны цахим хуудас

**Банк, санхүүгийн системд тогтвортой өсөлтийг бий болгож буй банк**  
Монгол Улсын банк, санхүүгийн салбарт нэг байгууллага эсхүл хувь хүн давамгайлаагүй эрүүл бүтэцтэй банк юм.


## Хувьцаа эзэмшигчид



## Өөрийн хөрөнгийн өгөөж | тэрбум ₮



## Нийт хөрөнгийн өсөлт | их наяд ₮



# ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


**2021 онд:** Эдийн засгийн өсөлт 1.4 хувьтай гарлаа. Оны эхнээс уул уурхайн салбар сэргэж эхэлсэн хэдий ч урд хөршийн хил гаалийн хязгаарлалт, тэвэр ложистикийн хүндрэлээс үүдэлтэйгээр аж үйлдвэр, барилгын салбарт хүндрэл бий болсон нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлахад ихээхэн нөлөө үзүүллээ. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан тэвэр, ложистикийн хүндрэлээс үүдэлтэй хэрэглээний үнэ өссөн.

**Төлөв байдал:** 2022 онд эдийн засаг 4-5 орчим хувьд өсөхөөр байна. Өсөлтийг сааруулж байгаа хүчин зүйлс нь дотоодын цар тахлын нөхцөл байдал, гадаад худалдаан дээр үүссэн гацаа зэргийг дурдаж болохоор байна. Энэ хэвээрээ импортын гацаа үргэлжлэх нь өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийг бууруулж, улмаар үнийн өсөлт цаашид эрчимжих эрсдэлтэй байна. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд цар тахлын хүнд нөхцөлд бодит сектор нэлээд хүндэрсэн. Тус нөлөө нь ирэх жилүүдэд санхүүгийн секторт хүчтэй нөлөөлөх магадлалтай байна. Тиймээс эдийн засагт үүсээд буй хүндрэлүүдийг бодлогын түвшинд шийдэх, тохируулга хийх нь үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

## 2021 онд эдийн засаг 1.4 хувиар өсөв.

2021 оны эхний улиралд уул уурхайн салбар сэргэсэн хэдий ч нөхцөл байдлаас шалтгаалан хил гааль дээр экспорт, импорт удаан хугацаанд гацсан нь бусад салбарт нөлөөлж эдийн засгийн өсөлтийг сааруулав.


Хил гаалийн нөхцөл байдлаас улбаатай экспорт буурч, импортын бараа бүтээгдэхүүнийн үнэ, өртөг нэмэгдсэн нь цэвэр экспортыг бууруулж байна.




## Тээвэрлэлт хүндрэлтэй байгаа ч үнийн өсөлтөөс шалтгаалж худалдааны эргэлт багасаагүй байна.

- Экспортын биет хэмжээ өсөлтгүй байгаа ч түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан нүүрсний орлого өмнөх оны мөн үеэс 2 дахин өсжээ.
- Импортын бодит хэмжээ өсөлтгүй байгаа ч дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтөөс хамаарч нефть, хүнсний бүтээгдэхүүний импортын дүн нэмэгджээ.

Экспортын гол бүтээгдэхүүн, төрлөөр




Импортын гол бүтээгдэхүүн, төрлөөр




# Төгрөгийн нэрлэсэн ханш тогтвортой байгаа нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад нөлөөллөө.

- Төлбөрийн тэнцэл ашигтай гарсан нь төгрөгийн бодит ханшийг чангаруулж, ирээдүйд төгрөгийн нэрлэсэн ханш чангарах хүлээлтийг бий болгож байна.
- Төлбөрийн тэнцэл 358 сая ам.долларын ашигтай гарсан ч, цаашид импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс улбаатай валютын гадагшлах урсгал нэмэгдэж болзошгүй.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл




# Инфляц өсөж, хадгаламжийн бодит хүү сөрөг болов.

- Хүнс, хатуу, түлшний үнэ тогтмол өссөн, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тээвэр, ложистик хэвийн ажиллахгүй байгаагаас үүдэн инфляц өндөр байна. Цаашид тээвэр, ложистик хэвийн түвшинд ажиллахгүй бол инфляцийн түвшин нэмэгдэх хандлагатай.
- Бодлогын хүү 0.5 нэгжээр оны төгсгөлд нэмэгдлээ.
- Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцийн нөлөөгөөр хугацаатай хадгаламжийн бодит хүү -5.1 хувьд хүрэв.

Бодлогын хүү, инфляци




Хадгаламжийн бодит ба нэрлэсэн хүү




# 2021 онд төсвийн үндсэн тэнцэлийн алдагдал өмнөх оны мөн үеэс буурав.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд ЗГ-аас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнээс хамаарч төсвийн үндсэн тэнцэл сүүлийн 3 жилд алдагдалтай гарчээ. Цаашид ч цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй бол төсвийн үндсэн тэнцлийн алдагдал урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна.

### Төсвийн орлого ДНБ-д эзлэх хувь



### Төсвийн зарлага ДНБ-д эзлэх хувь



2022\* төсвийн төсөөлөл

### Төсвийн тэнцэл (их наяд төгрөгөөр)

